



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/195

Булган сум

**Үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.3, 46.4 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2022 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам", Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны Х/74 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах зардлын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Зарцуулах эрх олгосон орлогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зарцуулж, нягтлан бодох бүртгэлд тусгахыг Худалдан авах ажиллагааны газар (Б.Баярцэнгэл)-т тус тус даалгасугай.


3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зарцуулалтын эрхийг нээж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
12 дугаар сарын 22-ны/ний өдрийн
А/А.95 дугаар захирамжийн хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭМЭЛТ ОРЛОГЫГ ЗАРЦУУЛАХ ЭРХ

д/д	Эдийн засгийн ангилал	Зардлын нэр	Ирүүлсэн санал (мянган төгрөг)	Хянасан дүн (мянган төгрөг)
1	2	3	4	5
Худалдан авах ажиллагааны газар (хөтөлбөрийн код 70418)				
1	80802/213204	Нэг удаагийн тэтгэмж	150.0	150.0
2	80101/210401	Бичиг хэрэг	160.0	160.0
3	80101/210406	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйл	485.0	485.0
4	80101/210702	Дотоод албан томилолт	1,370.0	1,370.0
Дүн			2,165.0	2,165.0